



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/140

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8¹.1.4 дэх хэсгийг үндэслэн **ТУШААХ** нь:

1. Биеийн тамир, спортын салбарын цахим мэдээллийн сангийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Биеийн тамир, спортын салбарын цахим мэдээллийн сангийн төсөл, бодлогын даалгаварыг 2017 оны IV улиралд багтаан боловсруулахыг Гадаад харилцаа, статистик, мэдээллийн технологийн хэлтэс /Н.Оюунбат/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Одонбаяр/-т даалгасугай.

ДАРГА



Ц.ШАРАВЖАМЦ

000000492

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8¹.1.4 дэх хэсгийг үндэслэн **ТУШААХ** нь:

1. Биеийн тамир, спортын салбарын цахим мэдээллийн сангийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Биеийн тамир, спортын салбарын цахим мэдээллийн сангийн төсөл, бодлогын даалгаварыг 2017 оны IV улиралд багтаан боловсруулахыг Гадаад харилцаа, статистик, мэдээллийн технологийн хэлтэс /Н.Оюунбат/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Одонбаяр/-т даалгасугай.

ДАРГА

Ц.ШАРАВЖАМЦ

Биеийн тамир, спортын газрын даргын 2017 оны ... сарын ... өдрийн ... тушаалын 1 дүгээр хавсралт

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

1	Ажлын хэсгийн дарга	<u>Н.Оюунбат</u>	Биеийн тамир, спортын газрын Гадаад харилцаа, статистик, мэдээллийн технологийн хэлтсийн дарга
2	Ажлын хэсгийн дэд дарга	<u>Х.Бакытжан</u>	Спортын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтсийн дарга
3	Ажлын хэсгийн дэд дарга	<u>Ч.Насанбат</u>	Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албаны дарга
4	Гишүүд	О.Гэрэл	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Биеийн тамир, спортын бодлогын газрын ахлах мэргэжилтэн
5		<u>Ж.Тунгалаг</u>	Биеийн тамир, спортын бодлогын газрын мэргэжилтэн
6		<u>С.Мөнх-Эрдэнэ</u>	Биеийн тамир, спортын бодлогын газрын мэргэжилтэн
7		Ц.Одонбаяр	Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга
8		Н.Батсүх	Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
9		Г.Одбаатар	Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтсийн дарга
10		Л.Онон	Гадаад харилцааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
11		<u>Б.Нямсүрэн</u>	Спортын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
12		<u>Б.Баярхүү</u>	Спортын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
13		О.Баттулга	Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
14		<u>О.Баасан</u>	Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
15		Ж.Баасансүрэн	Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
16		<u>Ж.Баясгалан</u>	Биеийн тамир, спортын газрын Үндэсний шигшээ багийн албаны мэргэжилтэн
17		<u>П.Бат-Очир</u>	Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албаны их эмч

18		<u>Ш.Болормаа</u>	Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албаны их эмч
19		Ш.Долгор	Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албаны ахлах мэргэжилтэн
20		Б.Эрдэнэваанчиг	Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албаны мэргэжилтэн
21		Б.Чаминчулуун	Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албаны мэргэжилтэн
22		Ё.Очирхүү	Гадаад харилцаа, статистик, мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн
23	Нарийн бичгийн дарга	<u>Б.Ганзориг</u>	Гадаад харилцаа, статистик, мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн

---o0o---

Биеийн тамир, спортын газрын даргын 2017 оны ... сарын ... өдрийн ... тушаалын 2 дүгээр хавсралт

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Зорилго.

Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн хангамжийн урсгалыг бий болгох, бүтэц зохион байгуулалтыг тодорхойлох, техник технологийг нэвтрүүлсэн цахим мэдээллийн сан бүрдүүлэх бодлогын даалгавар, төслийн боловсруулахад гол зорилго оршино.

Хамрах хүрээ.

Төрийн бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавихад шаардагдах биеийн тамир, спортын төр, төрийн бус болон хувийн өмчийн байгууллагын мэдээллийг хамарсан байна.

Ажил гүйцэтгэх хугацаа.

1. Биеийн тамир, спортын мэдээллийн сангийн бүтэц, урсгал, хяналт, мэдээллэх нэгдсэн системийн зураглалыг 2017 оны 06 сарын 30-ны Баасан гарагт гаргаж бэлэн болгоно.
2. Мэдээллийн цахим санг бий болгох бодлогын даалгаврыг 2017 оны 07 сарын 28-ны баасан гарагт боловсруулж дууссан байна.
3. Биеийн тамир, спортын мэдээллийн цахим сангийн төслийг 2017 оны 10 сарын 27-ны ны баасан гарагт боловсруулж гаргана.

Ажлын хэсгийн зохион байгуулалт.

Ажлын хэсгийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах үүднээс дараах хэлбэрийн зохион байгуулалтаар ажиллана. Үүнд:

1. Спортын чиглэлийн мэдээллийн бүтэц, урсгал, хяналтын системийн зураглалыг боловсруулах баг. Спортын мэдээллийн багт:
 - Спортын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтсийн дарга Х.Бакытжан
 - Спортын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Нямсүрэн
 - Спортын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн Б.Баярхүү
 - Үндэсний шигшээ багийн албаны мэргэжилтэн Б.Анар
2. Биеийн тамирын чиглэлийн мэдээллийн бүтэц, урсгал, хяналтын системийн зураглалыг боловсруулах баг. Биеийн тамирын мэдээллийн багт:
 - Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтсийн дарга Г.Одбаатар
 - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Биеийн тамир, спортын бодлогын газрын мэргэжилтэн Ж.Тунгалаг

- Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн О.Баасан
 - Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Баасансүрэн
3. Захиргааны мэдээллийн бүтэц, урсгал, хяналтын системийн зураглалыг боловсруулах баг. Захиргааны мэдээллийн багт:
 - Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга Ц.Одонбаяр
 - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Биеийн тамир, спортын бодлогын газрын ахлах мэргэжилтэн О.Гэрэл
 - Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Батсүх
 - Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн О.Баттулга
 4. Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний мэдээллийн бүтэц, урсгал, хяналтын системийн зураглалыг боловсруулах багт:
 - Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албаны дарга Ч.Насанбат
 - Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албаны их эмч П.Бат-Очир
 - Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албаны их эмч Ш.Болормаа
 - Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албаны мэргэжилтэн Ш.Долгор
 - Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албаны мэргэжилтэн Б.Чаминчулуун
 - Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албаны мэргэжилтэн Б.Эрдэнэваанчиг
 5. Дээрх багуудын боловсруулсан саналыг хүлээн авч Нэгтгэн боловсруулах баг байна. Нэгтгэн боловсруулах багт:
 - Гадаад харилцаа, статистик, мэдээллийн технологийн хэлтсийн дарга Н.Оюунбат
 - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Биеийн тамир, спортын бодлогын газрын мэргэжилтэн С.Мөнх-Эрдэнэ
 - Гадаад харилцаа, статистик, мэдээллийн технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Онон
 - Гадаад харилцаа, статистик, мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн Ё.Очирхүү
 - Гадаад харилцаа, статистик, мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн Б.Ганзориг

Ажлын хэсгүүдийн боловсруулах ажил.

1. Бүх шатны биеийн тамир, спортын байгууллагын мэдээллийн бүтэц, урсгал, хяналт, уялдааг хангасан мэдээллийн тогтолцооны цахим системийн зураглал боловсруулах
2. Мэдээллийн цахим санг бий болгоход шаардагдах бодлогын даалгаврыг боловсруулах
3. Биеийн тамир, спортын салбарын цахим мэдээллийн сангийн төслийг боловсруулах

Ажлын хэсгүүдийн гишүүд болон зохион байгуулалтын багуудын гүйцэтгэх даалгавар.

Нэгдүгээр хурал:

- Ажлын хэсгийн гишүүд өөрийн хариуцсан ажил, албан тушаалд шаардлагатай мэдээллийг ямар нэгэн эрэмбгүйгээр дугаарлаж бичнэ.
- Ажлын хэсгийн гишүүдийн гаргасан шаардлагатай мэдээллийн жагсаалтыг баг тус бүр нэгтгэнэ.
- Баг бүр нэгтгэн гаргасан мэдээллийн жагсаалтыг ажлын хэсгийн бүх гишүүдэд танилцуулна. Бусад багийн гишүүд санал гаргаж нэмж оруулах эсэх талаар хэлэлцэнэ.
- Баг бүрийн нэгтгэн гаргасан мэдээллийн жагсаалтыг эцсийн байдлаар ажлын хэсгийн дарга батална.

Хоёрдугаар хурал:

- Ажлын хэсгийн даргын баталсан нэгтгэсэн мэдээллийн жагсаалтад нэмэлтээр тусгах санал гаргах, хэлэлцэж тусгах
- Нэгтгэсэн мэдээллийн жагсаалтын мэдээллүүдийн задаргааг ажлын хэсгийн гишүүд бүр гаргана.
- Ажлын хэсгийн гишүүдийн мэдээллүүдийн задаргааг багийн түвшинд нэгтгэнэ.
- Багийн түвшинд нэгтгэсэн мэдээллүүдийн задаргааг ажлын хэсгийн түвшинд танилцуулна. Бусад багийн гишүүд санал гаргаж, нэмж оруулах эсэх талаар хэлэлцэнэ.
- Баг бүрийн гаргасан нэгтгэсэн мэдээллүүдийн задаргааг эцсийн байдлаар ажлын хэсгийн дарга батална.

Гуравдугаар хурал:

- Ажлын хэсгийн даргын баталсан нэгтгэсэн мэдээллүүдийн задаргаанд нэмэлтээр тусгах санал гаргах, хэлэлцэж тусгах
- Багуудын гаргасан нэгтгэсэн мэдээллүүдийн задаргааг хэн гаргаж цахим мэдээллийн санд оруулах, хэн хянах, хэн ашиглах, хэнд мэдээллийг хүргэх урсгалыг боловсруулах
- Баг бүр нэгтгэн гаргасан мэдээллүүдийн задаргаа, мэдээллийн урсгалыг ажлын хэсгийн түвшинд танилцуулна. Бусад багийн гишүүд санал гаргаж, нэмж оруулах эсэх талаар хэлэлцэнэ.
- Баг бүрийн нэгтгэн гаргасан мэдээллүүдийн задаргаа, мэдээллийн урсгалыг ажлын хэсгийн даргаар баталгаажуулна.
- Дээрх багуудын боловсруулсан саналыг “Нэгтгэн боловсруулах баг” хүлээн авна. Хүлээн авсан мэдээллийн сангийн боловсруулалтыг нэгтгэн мэдээллийн сангийн нэгдсэн зураглал буюу бодлогын даалгаварыг гаргана.

Дөрөвдүгээр хурал:

- “Нэгтгэн боловсруулах баг” мэдээллийн сангийн нэгдсэн зураглал буюу бодлогын даалгаварыг ажлын хэсгийн түвшинд танилцуулж нэмэлт саналыг тусгаж эцсийн төслийг боловсруулна.

Төсөл хүлээлгэн өгөх:

Биеийн тамир, спортын цахим мэдээллийн сангийн төслийг Биеийн тамир, спортын газрын даргад хүлээлгэн өгнө.

---o0o---